

**МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН
ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА, НИЙТИЙН УДИРДЛАГЫН СУРГУУЛИЙН
НИЙТИЙН УДИРДЛАГЫН ТЭНХИМ
МАГИСТР, ДОКТОРЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫН УДИРДАМЖ**

Сэдвийн хамрах хүрээ:

“Public Administration in troubling times – Managing challenges, charting the future”

Зорилго: Төрийн удирдлагын чиглэлээр онол практикийн ач холбогдол бүхий судалгааны шинэ бүтээл, үзэл санааг хөгжүүлэх, олон нийтэд түгээн дэлгэрүүлэх, харилцан санаа бодлоо чөлөөтэй солилцох, оюутны эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг дэмжихэд чиглэгдэнэ.

Хэзээ: 2021 оны 04-р сарын 08-ны өдрийн 14:00 цагт

Хаана: МУИС-ийн 5-р байр 203 тоотод

(Жич: хэрэв өөрчлөлт орвол тухайн үед эргэн мэдэгдэнэ).

I. Илтгэлийн бүтэц

Эрдэм шинжилгээний хурлын илтгэл дараах бүтэцтэй байна. Үүнд:

1. Удиртгал: Сэдвийн судлагдсан байдал, арга зүй
 2. Онолын судалгаа
 3. Судалгааны үр дүн
 4. Дүгнэлт
 5. Ном зүй
1. **Удиртгал:** Судалгааны үндэслэл, шаардлага, тавьсан зорилго, судалгааны асуултаа товч томъёолно.
 2. **Судалгааны онол, арга зүй:** Судалгаандаа дэвшүүлсэн таамаглал, түүнийгээ батлахын тулд ямар онолыг судалсан, ямар аргыг ашиглан судалгаа авч, хэрхэн гүйцэтгэсэн; цуглуулсан мэдээлэлдээ ямар аргаар боловсруулалт хийснийг багтаана.
 3. **Үр дүн:** Энэ хэсэгт судлаач өөрийн гаргаж авсан үр дүнг баталгаатай, логик дэс дараалал сайтай, эмх цэгцтэй, ойлгомжтой бичнэ.
 4. **Дүгнэлт:** Өөрийн судалгааны үр дүнг бусад судлаачдын судалгааны үр дүн, онолын янз бүрийн чиглэл, үзэл баримтлалтай хэрхэн холбогдох хийгээд өөрийн таамаглалаа хэрхэн баталсан, эсвэл үгүйсгэсэн, ямар дүгнэлтэнд хурч байгаа зэргийг ишлэл, баримт, баталгаа нотолгоотой гаргана.
 5. **Ном зүй:** Chicago Style- ийг ашиглана.

II. Тавигдах шаардлага:

1. Судалгааны ажлын сэдвээ тэнхимээс санал болгосон өрөнхий чиглэлийн хүрээнд сонгох,
2. Судалгааны ажлын сэдэв нь оновчтой, тодорхой, сонирхол татахуйц байх,
3. Удирдагч багштай байх,
4. Эрдэм шинжилгээний хурлын илтгэлээ A4, Times New Roman, мөр хоорондын зайд 1.5, үсгийн фонд 12, 10-15 хуудсанд багтаан бичих,
5. Ишлэл, зүүлт, ном зүйг Chicago Style ашиглан бичих; дараах хаягаар орж заавартай танилцана уу.
http://www.chicagomanualofstyle.org/tools_citationguide.html
6. Найруулга, үг үсгийн алдаагүй байх
7. Илтгэлээ 2021 оны 03-р сарын 31-ны өдөрт багтаан удирдагч багшдаа танилцуулах
8. Илтгэлээ 2021 оны 04-р сарын 05-ны өдрийн 18:00 цагаас өмнө puad_dep@num.edu.mn илгээнэ үү.

III. Илтгэлийн PPT бэлтгэх заавар

1. Нийтийн удирдлагын тэнхимиийн PPT template ашигласан байх,
2. PPT нь энгийн, ойлгомжтой, хүртээмжтэй байх,
3. Times new roman, үсгийн фонд 24
4. Слайд бүр дээрх үгийн тоо цөөн, өгүүлбэр энгийн, богино байх
5. Шаардлагатай мэдээлэл, сонирхолтой ишлэл, түлхүүр үг нэр томъёог бичих
6. Судалгаанд холбогдох зураг, график дүрс, хүснэгтийг тод харагдахуйц байдлаар оруулах, хэмжээ слайд бүрт ижил байх
7. Үгийн болон зургийн хөдөлгөөнт хэлбэрийг (animation) ашиглахгүй байх
8. Үсгийн хэмжээ, өнгө, үндсэн фон слайд бүрт ижил байх
9. Нэмэлт мэдээлэл/санааг үндсэн мэдээллээс жижиг фонтоор бичиж урд нь тусгай тэмдэглэгээ хийх
10. Гарчигаас бусад тохиолдолд том үсгээр бичихгүй байх
11. Хэт олон эсвэл цөөн слайд бэлтгэхээс зайлсхийх (нэг минут нэг слайд дүрмийг санах)
12. Хэрэв илтгэлийн агуулгад хэрэгтэй мультмедиа/ видео ашиглах болох PPT-ийн слайдад оруулж өгөх (embed)
13. Слайд бүрт байж болох утга найруулга, үг үсгийн болон бусад техникийн алдааг сайтар шалгах